

# “ХОРГО ХАЙРХАН” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2016 оны 03 сарын 16 өдөр  
хот

№ 2

Улаанбаатар

## Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйл, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2012 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 34 дүгээр тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, “Хорго Хайрхан” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн 2015 оны үйл ажиллагааг тайлагнах хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн байранд 2016 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 10:00 цагт 1 давхарын хурлын танхимд зарлан хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр оруулсугай.
  - a. Компанийн 2015 оны үйл ажиллагааны тайлан болон ТУЗ-ийн дүгнэлт,
  - b. Санхүүгийн тайлан болон аудитын хорооны дүгнэлт,
  - c. Компанийн ТУЗ-ийн болон Гүйцэтгэх удирдлагын 2016 оны цалин урамшуулал болон зардлын төсөв,
  - d. Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох,
  - e. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэх,
  - f. Компанийн тухай хуулийн 94 дүгээр зүйлд өөрчлөлт оросноор Хувьцаат компанийн дүрэмд аудитын байгууллагыг заавал ажиллуулахаар заахаар болсон тул компанийн дүрэмд холбогдох өөрчлөлтийг оруулах.
3. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2016 оны 3 дугаар сарын 28-ний өдрөөр тогтоосугай.
4. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар мэдээг 2016 оны 3 дугаар сарын 18-ний өдөр, өдөр тутмын 2-оос доошгүй сонин, телевиз болон орон даяар нэвтрүүлгээ түгээдэг радиогоор мэдээлэх, хурлын зар мэдээг мэдээлсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа анх мэдээлсэн хэлбэрийн дагуу дахин мэдээлэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
5. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.
6. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох бичиг баримтын жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар баталсугай. 02 дугаар хавсралтанд заасан бичиг баримтыг ажлын өдрүүдэд 09<sup>00</sup>-17<sup>00</sup> цагийн хооронд “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн төв оффис дээр танилцах эрхтэй болохыг дурьдсугай.

7. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудлаар санал авах саналын хуудасны загварыг гуравдугаар хавсралтаар баталсугай.
8. Хувьцаа эзэмшигчээс “Санал авах хуудас”-ыг хүлээн авах сүүлийн өдрийг харъяалагдах брокер, дилерийн компаниар нь дамжуулан хурал хуралдах өдрөөс ажлын 5-с доошгүй хоногийн өмнө байхаар тогтсугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах комиссын даргаар Р.Батболд, гишүүдээр Р.Ариунболд, Л.Энхбаатар нарыг тус тус томилсугай.
10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг удирдах хурлын даргаар Р.Ариунболд, тооллогын комиссын даргаар Л.Энхбаатар, гишүүдээр “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн зөвлөх О.Уранбайгаль, О.Тунгалаг нарыг тус тус томилсугай.

Төлөөлөн Удирдах  
Зөвлөлийн дарга



...../Р.Ариунболд/